

СҮХБААТАР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА, ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН
ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮНЭЛГЭЭНИЙ ДҮН

(2010 оны үйл ажиллагааны үр дүн)

№	Үзүүлэлт	Үр дүнгийн үнэлгээ		
		хувь	оноо	
1	Бодлогын зорилтын хэрэгжилтийн үр дүнгийн үнэлгээ	1.Үндэсний хөгжлийн цогц бодлогын хэрэгжилт	80.5	4.02
		2.Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт	53.2/106.3	5.00
		3.Үндэсний хөтөлбөрүүдийн хэрэгжилт	73.0	3.65
Үнэлгээний дундаж оноо				4.22
2	Бодлогын зорилтын хэрэгжилтийн зохицуулалтын үнэлгээ	1.Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх Үндсэн чиглэлийн биелэлт	90.0	4.50
		2.Хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийн хэрэгжилт	89.3	4.46
		3.Монгол Улсын Ерөнхий сайдтай байгуулсан батламжийн хэрэгжилт	100.0	5.00
		4.Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт	53.1/106.3	5.00
Үнэлгээний дундаж оноо				4.74
3	Байгууллагын үйл ажиллагааны үр дүнгийн үнэлгээ	1.Эрхлэх асуудлын хүрээнд төсвийн ерөнхийлөн захирагчаас аймаг, нийслэлийн Засаг даргатай байгуулсан гэрээний үүргийн биелэлт	96.4	4.82
		2.Төсвийн ерөнхийлөн захирагчаас Ерөнхий менежертэй байгуулсан үр дүнгийн гэрээний биелэлт	95.0	4.75
Үнэлгээний дундаж оноо				4.79
4	Байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлын үнэлгээ	1.Үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдал	95.7	4.79
		2.Хүний нөөцийн бодлогын ил тод байдал	90.8	4.54
		3.Төсөв, санхүүгийн ил тод байдал	77.1	3.86
		4.Бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны ил тод байдал	91.0	4.55
Үнэлгээний дундаж оноо				4.44
5	Үйл ажиллагааны үр дагаврын үнэлгээ	1.Эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтийн үнэлгээ	89.6	4.48
		2.Хэрэглэгчийн үнэлгээ	76.7	3.83
Үнэлгээний дундаж оноо				4.16
Ерөнхий үнэлгээ			89.7	4.48

СҮХБААТАР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА, ТАМГЫН ГАЗРЫН
2010 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ,
ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН ТУХАЙ ТАЙЛАН

Нэг. Бодлогын зорилтын хэрэгжилтийн үр дүнгийн үнэлгээ

1.1. Үндэсний хөгжлийн цогц бодлогын хэрэгжилтийн талаар :

1. Мянганы хөгжлийн зорилтод суурилсан үндэсний хөгжлийн цогц бодлогоос 66 зорилтыг хяналтанд авч аймгийн Засаг даргын Тамгын газрын 5 хэлтсээр харъяаллын дагуу хэрэгжилтийн явцад хяналт тавиулж бодлогын удирдлагаар орон нутгийн төр, захиргааны байгууллагуудыг ханган ажиллаж, биелэлтийн тайланг хагас, бүтэн жилээр гарган аймгийн Засаг дарга, Тамгын газрын бие бүрэлдэхүүнд мэдээлдэг болов.

Сумдтай холбоотой зорилтуудыг 2010 оны эхэнд жагсаалтаар гарган хүргүүлж хэрэгжилтийн явцын талаар тайлан, мэдээг гаргуулан ажил дүгнэхэд гол үзүүлэлт болгож байна.

Цогц бодлогын хүрээнд суралцагчдад хэрэгцээнд нь нийцсэн боловсрол эзэмших тэгш боломж бүрдүүлэх, гэр бүлийг хүний аж төрөх таатай орчин болгоход чиглэсэн бодлого, хүн амын эмзэг бүлгийг дэмжих халамжийн тогтолцоог төлөвшүүлэх гэсэн бодлогын зорилтуудын гүйцэтгэл хангалттай сайн түвшинд хэрэгжиж байгаа бол малын тэжээлт үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх цогц арга хэмжээ, мэдээлэл харилцааны технологийн ололтыг нийгэм, эдийн засгийн бүх салбарт нэвтрүүлэх, ядуурлын түвшинг эрчимтэй бууруулах гэсэн зорилтууд 25-50 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжсэн байна. Иймээс үндэсний хөгжлийн цогц бодлогын 19 заалтын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэхэд анхаарч ажиллах нь зүйтэй байгаа юм.

2010 оны ажлын гүйцэтгэлээр Үндэсний хөгжлийн цогц бодлогын хэрэгжилтийн явц 80,35 хувьтай байна.

1.2. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний биелэлтийн талаар :

Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний 87 зорилтын 161 арга хэмжээний биелэлтийг хяналтанд авч хэрэгжилтийг хагас, бүтэн жилээр тооцож байна.

Тус аймагт Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрөөс дэд бүтцийг хөгжүүлэх, иргэдийг орон сууцжуулах, төрийн үйлчилгээ, мэдээллийг хөнгөн шуурхай болгох, хот суурин газрын тохижилт, гадаад хамтын ажиллагаа, бизнесийн орчныг сайжруулах, төсөв, санхүүгийн чиглэлийн зэрэг зорилтууд үр дүнд хүрч тодорхой ажлуудыг хийж гүйцэтгэсэн байна.

2010 онд улс, орон нутаг, төсөл хөтөлбөрийн 8,8 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийж, хийгдсэн бүтээлч ажлынхаа нээлтийг аймгийн төвд нэгдсэн журмаар хийж аймаг, сум, агентлаг алба бүрийн гол гол ажлуудыг нэгтгэн дүгнэж сурталчиллаа. Үүнд :

-Сүхбаатар аймаг хөрөнгө оруулалт хөгжлийн чуулган

-Аймгийн төвд 100 гаруй ажлын байр бүхий төвлөрсөн худалдааны зах

-Зорчигч үйлчлүүлэгчдийн танхим, авто машины зогсоол, сүүдрэвч, зочид буудал, хоол хүнсээр үйлчлэх цэг бүхий авто вокзал

-Хүүхдийн иж бүрдэл бүхий тоглоомын болон спорт тоглоомын талбай

-Бага дунд орлоготой иргэдэд зориулсан цэвэр, бохир, дулаанд холбогдсон 75 айлын сууц

-30 ортой халдварт, сүрьеэгийн эмнэлэг

-Хатуу хучилттай авто замын дагуу 2,3 км явган зорчигчийн зам

-200 авто машины зогсох авто зогсоол

-Иргэдийн чөлөөт цагаа боловсон өнгөрүүлж амрах зориулалтаар үйлчилгээний ORANGE төв, LED дэлгэц

-100 өрхийн жишиг хороолол

-Аймгийн төвийн гол гудамжийг тохижуулсан өргөн чөлөө

-Цэцэрлэгт хүрээлэн

-Аймгийн төвлөрсөн хогийн цэгийг ландфиллийн аргаар тохижуулсан зэрэг томоохон бүтээн байгуулалтын ажлууд хийгдсэний зэрэгцээ нийгмийн салбаруудын хүрээнд ч багагүй ахиц өөрчлөлт гарлаа. Тухайлбал : Наран, Асгат, Халзан сумдын одоо баригдаж буй тус бүр нь 320 хүүхдийн суудалтай хичээлийн байр ашиглалтанд орсноор бүх сургууль стандартын шаардлага хангасан хичээлийн байраар хангагдаж, сургуулийн өмнөх болон бага боловсролын хамран сургалт 77,8-95,5 хувьд хүрсэн нь Засгийн газрын мөрийн хөтөлбөрийн зорилтыг бүрэн хангаж байна. Нөгөө талаар ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн багш, хүмүүжүүлэгчдийн хангалт 97,4-99,2 хувьтай байгаа нь мэргэжлийн багшаар үндсэндээ хангагдсан хэрэг юм.

Тус аймгийн хүүхдийн 20 цэцэрлэг зориулалтын байртай болоод байна.

Соёлын байгууллагуудын хувьд мэргэжлийн боловсон хүчнээр хангах, материаллаг баазыг бэхжүүлэхэд тайлант онд 131,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдлээ.

Эрүүл мэндийн салбарт зориулалтын байр барьж ашиглах, эмч мэргэжилтний хүрэлцээ хангамжийг нэмэгдүүлэх хүрээнд бодлогын чанартай олон арга хэмжээ. авснаар эмнэлгийн мэргэжилтний хангалт 84 хувь, үүнээс нэгдсэн эмнэлгийн их эмчийн хангалт 100 хувь, сумдын болон багийн эмчийнх 80,0-71,8 хувьтай байгаа нь сүүлийн жилүүдэд ахиж буй үзүүлэлт юм.

Харин тоног төхөөрөмжийн хангалт 88 хувьд хүрч, орчин үеийн шаардлага хангасан байртай боллоо.

-2010 онд эхийн эндэгдэл гараагүй бөгөөд хүүхдийн эндэгдэл 21,3 хувьтай байгаа нь улсын дунджаас дээгүүр харин аймгуудын дунджаас доогуур байна.

-Нийт халдварт өвчний гаралт 38,2, үүнээс вируст гепатит 62 пормилиэр буурч жилийн эцэст аймгийн хүн амын тоо өссөн үзүүлэлттэй гарлаа.

Сүүлийн хоёр жилд нийт 1649 ажлын байр шинээр бий болж, нийтийг хамарсан ажилд 1298 иргэнийг ажиллуулж ажилгүйдлын түвшинг 4 хувь болгожээ.

2009 онд 212, 2010 онд 269 ядуу өрхийн амьжиргааг дээшлүүлж байнгын орлогын эх үүсвэртэй болгосноор ядуурлын түвшин 2009 онд 18,9 хувь байснаа 2010 онд 15,1 хувь болж буурлаа.

Аймгийн эдийн засгийн үндэс болсон мал аж ахуй, байгаль цаг агаарын харьцангуй тааламжтай нөхцөлд урьд оноосоо 190 гаруй мянган толгойгоор өсч аймгийн дүнгээр сүүлийн 2 жил дараалан мал сүргээ таван төрөл дээр нь өсгөлөө.

2010 онд татвар төлөгч аж ахуйн нэгжийн тоо өссөнөөр орон нутгийн төсвийн орлого 7,9 тэрбум төгрөгт хүрч төлөвлөснөөс 1,9 дахин давж биелэгдлээ. Түүнчлэн хууль, тогтоомжийн хүрээнд орон нутагтаа төвлөрүүлж болох орлогын эх үүсвэрүүдийг судлан боломжтой бүхий л эх үүсвэрийг дайчилж 400 гаруй сая төгрөгийг нэмж төвлөрүүлэв.

Тайлант онд нийт зээлийн хэмжээ өмнөх оноос 6,7 тэрбум төгрөгөөр өсч 19,6 тэрбум төгрөгт хүрсэн бөгөөд чанаргүй зээлийн хэмжээ өмнөх оноос 2,0 хувиар буурч иргэдийн хадгаламж 4,0 тэрбум төгрөгөөр өсч 11,4 тэрбумд хүрчээ.

Өнөөдрийн байдлаар аймагт дэд бүтцийн салбараас эрчим хүч, холбоо хурдацтай хөгжиж бүх сум өндөр хүчдэлийн шугамд холбогдож, хөдөөгийн нийт өрхийн 85 хувь нь нар, салхины сэргээгдэх эрчим хүчээр хангагдаад байна. Аймгийн төв, хөдөөгийн хэд хэдэн сум шилэн кабель, интернетэд, бүх сум үүрэн холбооны 1-4 операторт холбогдож 6 сувгийн телевизийн нэвтрүүлэг үздэг боллоо.

Аймгийн хэмжээнд урьдчилсан байдлаар аж үйлдвэрийн бүтээгдэхүүний борлуулалт 104,6 тэрбум төгрөгт хүрч урьд оноос 2,7 тэрбум буюу 2,7 хувиар өсч нэг хүнд ногдох дотоодын нийт бүтээгдэхүүн 2,1 сая төгрөгт хүрч аймаг, нийслэлүүдийн дотор 5 дугаарт орох боллоо.

Харин хөтөлбөрийн хүрээнд дэвшигдсэн бэлчээрийн менежментийг боловсронгуй болгох, дотооддоо үр тариа тариалалт, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний хангалт зэрэг бодлогын зорилтуудын хэрэгжилт удааширч байна. Иймээс эдгээр зорилтуудыг хэрэгжүүлэхэд Засгийн газар, салбарын яамдууд, аймаг орон нутаг ажлын уялдаагаа сайжруулахад анхаарах нь чухал болоод байна.

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрөөс Сүхбаатар аймагтай холбоотой заалтын биелэлт 2010 онд 106,3 хувьтай байгаа болно.

1.3. Үндэсний хөтөлбөрүүдийн хэрэгжилтийн талаар :

Үндэсний хөтөлбөрүүдийн хэрэгжилт 72,98 хувьтай байна. Хөтөлбөрүүдийн хэрэгжилтийн явцад аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргаа удирдлагын хэлтэс 2, хууль зүйн хэлтэс 7, Нийгмийн хөгжлийн хэлтэс 25, Хөгжлийн бодлогын хэлтэс 42, Санхүү, төрийн сангийн хэлтэс 3, бүгд 79 хөтөлбөрийг хяналтанд байлган 2010 оны жилийн эцсээр тайлан гаргаж ирүүлэхээс 51 хөтөлбөрийн хэрэгжилтийн явц мэдээлэгдлээ.

2010 оны байдлаар аймгийн хэмжээнд 51 хөтөлбөрийн биелэлтийг тооцож гаргаснаас 100 хувийн биелэлттэй 3 хөтөлбөр, 90 ба түүнээс дээш хувийн биелэлттэй 10 хөтөлбөр, 50 ба түүнээс доош хувийн биелэлттэй 8 хөтөлбөр байна.

Үндэсний хөтөлбөр хэрэгжсэнээс хойш хийсэн ажлын биелэлтийг тооцож үзэхэд 100 хувийн биелэлттэй 3 хөтөлбөр, 90 ба түүнээс дээш хувийн биелэлттэй 8 хөтөлбөр, 50 ба түүнээс доош хувийн биелэлттэй 8 хөтөлбөр байна.

Нийт гүйцэтгэл гарсан хөтөлбөрүүдээс монгол хөөмий, монгол уламжлал бий биелгээ, жендерийн тэгш байдлыг хангах, өсвөр үе залуучууд гэсэн хөтөлбөрүүдийн хэрэгжилт удаашралтай байна. Энэ нь хөрөнгө санхүүгийн хүрэлцээгүй байдал ялангуяа хөтөлбөр хэрэгжүүлэхтэй холбоотой зардал төсөвт суудаггүйгээс шалтгаалан үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн явц удааширч байна. Жил бүрийн төсвийн төсөлд тодорхой хэмжээний хөрөнгийг тусгадаг ч Сангийн яаман дээр хасагддаг учраас ямар ч хөрөнгийн эх үүсвэргүй болдог. Иймээс хөтөлбөрийн хэрэгжилтийг ханган ажиллахад холбогдох

салбарын яам, газрууд аймаг орон нутагтай хамтарч ажиллах, хамтын уялдаагаа сайжруулах шаардлага ч байна. Үндэсний хөтөлбөр, Засгийн газрын шийдвэрийг хэрэгжүүлэхэд хөрөнгө санхүүгийн хувьд хязгаарлагдмал байх нь орон нутгийн түвшинд гарч буй гол бэрхшээл болж байна.

Хоёр: Бодлогын зорилтын хэрэгжилтийн зохицуулалтын үнэлгээ.

2.1. Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2010 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлтийн талаар:

Монгол улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлээс Сүхбаатар аймагтай холбоотой заалтын биелэлт үндсэндээ бүрэн хэрэгжиж, Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлтэй аймгийн жил жилийн үндсэн чиглэлийг уяалдуулан хийж нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагуудын хуралдаанаар хэлэлцүүлэн дүгнэлт өгүүлэн ажиллаж ирлээ.

2010 оны жилийн эцсийн байдлаар эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлт 90 хувьтай байна.

2.2. Хууль тогтоомж, Засгийн газрын тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн талаар:

Монгол Улсын Засгийн газрын 2006 оны 160-р тогтоолын дагуу “Хууль тогтоомж, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, үр дүн, биелэлтийг дүгнэх, мэдээлэх журам”-д заасны дагуу хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийн хэрэгжилтийн явцыг улирал бүрээр тооцож ЗГХЭГ, нийтэд мэдээлж ажиллав.

Хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийн хэрэгжилтийг хангуулах зорилгоор хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа тогтоол, шийдвэрүүдийн жагсаалтыг аймгийн Засаг даргын Тамгын газрын 5 хэлтэс, 13 сумдад оны эхэнд гарган хүргүүлж улирал тутам хэрэгжилтийн явцаар тайлан, мэдээ авч хяналт-шинжилгээ хийж зөвлөмж өгөн ажиллаж байна.

2010 оны жилийн эцэст УИХ-ын тогтоол 5, Ерөнхийлөгчийн зарлиг 2, ҮАБЗ-ийн зөвлөмж 1, Засгийн газрын тогтоол 174, Засгийн газрын хуралдааны тэмдэглэл 16 бүгд 198 тогтоол, шийдвэрийн 319 заалтын хэрэгжилтийн дүнг 89,31 хувийн биелэлттэйгээр 2011 оны эхэнд Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хяналт шинжилгээ үнэлгээний хэлтэст гаргаж хүргүүлсэн.

Хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийн хэрэгжилтийг хэрхэн зохион байгуулах, энэ талаар ЗГ-ын 2006 оны 160 дугаар тогтоолын дагуу тайлан, мэдээг гаргаж байх ажлын арга зүй, стандартыг мөрдүүлэх талаар аймгийн бүх сумдын ЗДТГ-ын дарга, дотоод ажил хариуцсан ажилтнуудад зөвлөмж өгсөний зэрэгцээ, 19 агентлаг, албадын үйл ажиллагааны явцтай танилцаж зааварчлага өгч ажилласан нь тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийн явцад хандах хандлага өмнөх жилүүдээс сайжирсан гэж үзэж байгаа болно.

2.3. Монгол Улсын Ерөнхий сайдтай байгуулсан батламжийн биелэлт:

Монгол Улсын Ерөнхий сайдтай байгуулсан батламжийн биелэлтийг заалт бүр дээр нь тайлант оны түвшинд тавигдсан зорилтоор тооцон үзэхэд бүрэн биелүүлж чадсан. Ялангуяа төсөв санхүүгийн бүрдүүлэлт, зарцуулалт, орлого төвлөрүүлж хуримтлал буй болгох эдгээрт тавих хяналт, Засгийн газрын болоод Засаг даргын хөтөлбөрийн биелэлтийг хангах, хууль ёсыг сахих зэрэг ажлаар хангалттай сайн ажиллаж ард иргэд, аймгийн ИТХ-ын хуралдаанаас хангалттай сайн үнэлгээ авсан.

Батламжаар хүлээсэн үүргээ биелүүлэхийн тулд ЗГ-ын ХЭГ, бодлогын болоод хэрэгжүүлэгч яам, агентлагуудтай ажил төрлийн байнгын холбоотой ажиллаж ирлээ.

2.4. Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн талаар:

Аймгийн Засаг даргын 2008-2012 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийн 192 зорилт байгаа бөгөөд засаглалын эхний 2 жилд хийж гүйцэтгэх ажлын биелэлт 106,3 хувьтай байна. Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрөөс тасарч байгаа болон тасарч болзошгүй заалт байхгүй байгаа болно. Жил бүр үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн талаар аймгийн ИТХуралд тайлан тавьж хангалттай үнэлэлт авч байгаагийн зэрэгцээ бүх сумдад ажлаа биечлэн тайлагнаж иргэдийн санал хүсэлтийг сонсож түүний мөрөөр арга хэмжээ авч ирэв. (Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилттэй холбоотой зарим ажлын фото мэдээллийг хавсаргав)

Гурав: Байгууллагын үйл ажиллагааны үр дүнгийн үнэлгээ.

3.1. Төсвийн ерөнхийлөн захирагчаас аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээний биелэлт :

Аймгийн Засаг дарга нь тайлангийн хугацаанд Засгийн газрын тэргүүн болон шадар сайд, Засгийн газрын гишүүн 8 сайд, бусад 2 газартай бүтээгдэхүүн нийлүүлэх, санхүүжилтын гэрээ байгуулан үр дүнг тооцон ажиллаж гэрээгээр хүлээсэн үүргийн биелэлт 87,2-126,3 хувьтай байна. Үүнээс Авто замын газартай байгуулсан гэрээний биелэлт 87,2 хувьтай биелэгдсэн нь хамгийн бага үзүүлэлт байна.

Гэрээгээр хүлээсэн үүргийн биелэлтийг хангахтай холбогдуулан 2010 онд яам, агентлагуудад хандаж 13 удаа албан бичгээр асуудал тавьж байсны 95,4 хувь нь биелэгдлээ.

Гэрээнд заагдсан бүтээгдэхүүн нэг бүрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд сумдын засаг дарга, хэлтэс, агентлаг, албадын дарга нартай байгуулсан бүтээгдэхүүн нийлүүлэлт санхүүжилтийн гэрээнд тусган тогтмол хянаж, улирал тутам холбогдох хэлтэс, агентлаг, албадаас биелэлтийг авч хяналт шинжилгээ хийж үр дүнг Засаг даргын зөвлөлөөр хэлэлцэн хэрэгжилтийг хангах удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээг цаг алдалгүй авч ажиллалаа.

Энэхүү гэрээг хэрэгжүүлэх үүднээс гэрээ байгуулагч талуудын төсвийн ерөнхийлөн захирагчтай байнгын холбоотой ажиллаж төсөв хөрөнгө, удирдлага, зохион байгуулалтын болон бусад ажил дээр дэмжлэг туслалцаа авах замаар хамтран ажиллах талаар түлхүү анхаарсан болно.

2010 онд нийт 12 яам, агентлаг, тусгай газартай гэрээ байгуулсны биелэлтийг тооцож нэгтгэж үзвэл 96,4 хувийн хэрэгжилттэйгээр дүгнэгдэж тус тусын газар яамдад хүргэгдсэн болно.

3.2. Төсвийн ерөнхийлөн захирагчаас ерөнхий менежертэй байгуулсан үр дүнгийн гэрээний биелэлт:

Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга буюу Ерөнхий менежертэй 2010 онд 18 төрлийн бүтээгдэхүүн худалдан авахаар гэрээлсний 94,3 хувь нь хугацаандаа биелэгдэж, 15,7 хувь нь хугацаа хожимдож биеллээ. Ерөнхий менежертэй байгуулсан үр дүнгийн гэрээний чанар 95,0 хувьтай гэж үзэв.

Дөрөв. Байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлын үнэлгээ

4.1. Үйл ажиллагааны ил тод нээлттэй байдал

Аймаг, сумдын Засаг даргын Тамгын газар, Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, албад өөрийн үйл ажиллагааны ил тод байдлыг хангахын тулд юуны өмнө тус тусын байгууллагынхаа стратегийн зорилго, зорилт, тэргүүлэх чиглэлээ боловсруулж, ажилтан бүрийн хариуцсан ажил үүргийн хуваарийг тодорхой болгосон байна. 2010 онд Сүхбаатар аймаг-хөрөнгө оруулалт, хөгжлийн чуулганыг гадаад 9 орны болоод дотоодын хөрөнгө оруулагч, хандивлагч нарын 300 гаруй төлөөлөгчийг оролцуулан зохион байгуулж аймгийнхаа хөгжлийн тэргүүлэх чиглэлийг, Уул уурхайн үйлдвэр, Эрчимжсэн мал аж ахуй, Транзит тээвэр, Хил орчмын аялал жуулчлал гэж тодорхойлон ажиллаж олон арван бүтээн байгуулалтын ажлыг өрнүүлж эхэлжээ.

Үүний зэрэгцээ аймгийн нийт сумдын 50 хувь нь стратегийн зорилт, зорилго, тэргүүлэх чиглэлээ тодорхойлж эдийн засгаа 2009-2020 он хүртэл хөгжүүлэх мастер төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлж эхлэсэн байна.

Түүнчлэн төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээ зөрчигсөд, ажил, албандаа хариуцлагагүй хандагсадтай дор бүр нь хариуцлага тооцож шаардлагатай гэж үзвэл нийтэд мэдээлж хариуцлагын түвшинг өндөржүүлэх, төрөөс иргэдэд үзүүлэх үйлчилгээний нэр төрлийг олшруулах, аль болох иргэдэд ойр дөт байж үйлчлэх, үйлчилгээг хөнгөн шуурхай чирэгдэлгүй болгоход анхаарлаа хандуулж ажиллажээ. Үүний зэрэгцээ аймгийн төр захиргааны байгууллагаас гаргах шийдвэрийн төслийг боловсруулахдаа холбогдох байгууллага, албан тушаалтны саналыг авахын зэрэгцээ иргэний нийгмийн байгууллага, тэдний төлөөллийг оролцуулдаг болсон нь үр дүнгээ өгч байна.

Байгууллага, албан тушаалтанд ирсэн аливаа өргөдөл, гомдлыг судалж барагдуулах ажлыг тухай бүрд нь хэрэгжүүлж хариуг эзэнд нь мэдэгддэг, иргэдэд тайлагнадаг журам тогтоож хэвшил болжээ.

Энэхүү зорилтын хүрээнд дэвшүүлсэн зорилтуудын гүйцэтгэл үр дүн хангалттай түвшинд хэрэгжсэн байна.

4.2. Хүний нөөцийн бодлогын ил тод байдал

Энэ зорилтын хүрээнд төрийн албан хаагчдыг шилж сонгож зөв байршуулах, төрийн албанд ажиллагсадыг сургаж, бэлтгэх, давтан сургаж мэргэшүүлэх ажлыг тусгай бодлого, төлөвлөгөөтэйгөөр зохион байгуулж байна. “Төрийн албан хаагчийн нийгмийн баталгаа” “Байгууллагын албан хаагчдын сурах сургалтын хөтөлбөр”-ийг боловсруулан төрийн албан хаагчдын сургах, давтан сургах арга хэмжээг тусгай төлөвлөгөө гарган албан хаагч нэг бүрийг хамруулах талаар бодлого боловсруулан ажиллаж байгаа нь зохих үр дүнд хүрч байна.

Хүний нөөцийн үйл ажиллагаанд үнэлгээ дүгнэлт өгөхдөө зөвхөн удирдлагын зүгээс ханддаг байсан хандлагыг өөрчилж ажилтан бүрийг өөрсдийг нь оролцуулдаг болсон нь ажлын үр дүн үнэлгээний бодит байдалд чухал нөлөө үзүүлдэг болжээ. Үүнээс гадна Төрийн албаны мэргэшлийн шалгалт авах зар, сул ажлын байрны захиалгыг иргэд хөдөлмөрчдөд ил тод нээлттэй байлгахад анхаарч Төрийн албаны зөвлөл болон аймгийн цахим хуудсанд байршуулах, орон нутгийн 2 телевиз, FM радиогоор сурталчлан таниулж иргэд олон түмэнд хүргэж ажилласан байна.

Засаг даргын Тамгын газрын албан хаагчдын дунд байгууллагын үйл ажиллагаа нээлттэй байдлын талаар аймгийн төвийн 6 албан газар, 4 сумын төрийн албан хаагчид, Сүхбаатар, Баруун-Урт, Мөнххаан сумдын иргэдийн дунд төрийн албаны ил тод байдал, сэтгэл ханамжийн судалгааг нийт 360 хүнээс авч харьцуулсан шинжилгээ хийж үзэхэд судалгаанд хамрагдагсдын 87,8 хувь нь байгууллагын үйл ажиллагааг ил тод нээлттэй гэж

үзсэн бол үлдсэн 22 хувь нь төр, иргэдийн холбоог ойртуулж ажиллах нь зүйтэй гэсэн дүн гарчээ. Энэхүү санал санаачлагыг хэрэгжүүлэх зорилгоор байгууллагын удирдлагын шийдвэр, төсвийн зарцуулалт зэргийг тухай бүр нь иргэд хөдөлмөрчдөд орон нутгийн телевизээр нээлттэй танилцуулж байгаа нь тодорхой үр дүнг өгч байна.

4.3.Төсөв, санхүүгийн ил тод байдал

Төсвийн ил тод байдлыг хангах ажлын хүрээнд төсвийн төслийг боловсруулах явцад иргэд байгууллагаас ирсэн санал хүсэлтийг судлан тусгаж, төсвийн зардлын зүйлээр болон хөтөлбөрт төсвөөр боловсруулан Сангийн яаманд хянуулж, орон нутгийн төсвийг ИТХ-аар хэлэлцүүлэн сумдад хүргүүлэхийн хамт, батлагдсан төсөв, төсөл арга хэмжээг аймгийн цахим хуудсанд тавьж төсвийн гүйцэтгэл, орлого, зарлагын сар, улирал жилийн эцсийн мэдээг статистикийн мэдээллийн сар тутмын эмхэтгэлд нийтлэн, байгууллагын ил тод байдлын мэдээлэлийн самбарт тавин ажиллаж байна.

Нөгөө талаар элдэв хардлага, буруу хандлага дагуулдаг тендер зарлах, төсөл, хөтөлбөр шалгаруулах, зээл тусламж олгох зэрэг хөрөнгө мөнгөтэй холбоотой үйл ажиллагааг эрхлэх комисс, зөвлөл, хороо, ажлын хэсэгт иргэний нийгмийн байгууллагын төлөөллийг тогтмол оролцуулж, Аудит, Мэргэжлийн хяналтын газар зэрэг хяналтын байгууллагын төлөөллийг байлцуулдаг нь үр дүнгээ өгч эхэлжээ.

Аймаг болон байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд жил бүр аудит хийлгэж түүний дүнг олон нийтэд мэдээлж, аймгийн ВЭБ сайт, боломжгүй газар самбар мэдээллийн хэрэгслээр сурталчилдаг боллоо. Үүнээс гадна улсын мэргэжлийн хяналтын газрын удирдамж чиглэлийн дагуу аймгийн ЗДТГ-аас хэрэгжүүлж буй салбарын ажил тус бүрт хяналт шалгалтын ажил хийгдэж хангалттай сайн үнэлгээг авсан байна.

Гэвч цаашид төсөв, санхүүгийн ил тод байдлыг хангах зорилтын хүрээнд хууль тогтоомжид заасан төлбөр, хураамжийг үйлчлүүлэгчээс авч, түүний хэмжээний тухай цахим хуудсаар болон бусад хэлбэрээр олон нийтэд мэдээлэх, үйлчилгээний хөлс болон төлбөр, хураамж авах хэлбэрийг боловсронгуй болгох чиглэлээр тодорхой арга хэмжээ авч хэрэгжүүлсэн байх зэрэг зорилтын хэрэгжилтийг хангаж ажиллах хэрэгтэй байна.

4.4.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны ил тод байдал:

Тендер шалгаруулах үйл ажиллагааны бэлтгэлийг чанартай хангах, нийтэд мэдээлж ил тодоор сурталчлах зорилгоор цахим хуудас, хэвлэлийг өргөн ашиглаж байна.

Худалдан авсан бараа, ажил үйлчилгээний тайланг олон нийтэд мэдээлдэг журам тогтжээ. Мөн тендэрийн хорооны гишүүдийг чадваржуулах сургалтанд хамруулах, тендэр шалгаруулалтын хороонд иргэний нийгмийн төлөөллийг оролцуулдаг нь үр дүнтэй ажил болж байна.

Харин 2010 онд инженерийн хийцтэй уст цэг шинээр гаргах ажил, 30 ортой Халдварт, сүрьеэгийн эмнэлэгийн барилга угсралт, аймгийн төвийн хог хаягдлын цэгийг ландшафтийн аргаар тохижуулах 3 худалдан авах ажиллагаанд тендерт оролцогчдоос гомдол ирсэн ч гомдлын хариуг хуулийн хугацаанд хүргүүлж шийдвэрлэсэн байна.

Ийнхүү байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлыг илтгэх шалгуур үзүүлэлтийн биелэлтийг бүхэлд нь тооцож үзвэл **90,1** хувийн гүйцэтгэлтэй, **4,50** оноотой байна.

Тав: Үйл ажиллагааны үр дагаврын үнэлгээ.

5.1.Аймгийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтийн үнэлгээ :

Эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтийн үнэлгээг “Яам болон аймаг, нийслэлийн Засаг дарга, Тамгын газрын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийх, үр дүнг үнэлэх журам”-ын 4 дүгээр хавсралтаар гаргасан тоон үзүүлэлтэд тулгуурлан дүн шинжилгээ хийж үзэхэд дараахь байдалтай байна.Үүнд:

- Эдийн засгийн 21 үзүүлэлтээс 20 үзүүлэлтийн биелэлтийг тооцоход 13 үзүүлэлт 100 хувийн үнэлгээтэй буюу 5 оноо, 2 үзүүлэлт “0” хувийн үнэлгээтэй буюу “0” оноо, үлдсэн 6 үзүүлэлтийн 5 нь 18.9-98.5 хувийн үнэлгээтэй буюу 0.94-4.92 оноо авч харин “Тариалангийн талбайд байгуулсан ойн зурвасны хэмжээ (га)” гэсэн үзүүлэлтийг шалгуур үзүүлэлтээс хасаж тооцов.

-Нийгмийн 21 үзүүлэлтээс 16 үзүүлэлт 100 хувийн үнэлгээ буюу 5 оноо, 2 үзүүлэлт “0” хувийн үнэлгээтэй буюу нойл оноо, 3 үзүүлэлт 95.7-99.3 хувийн үнэлгээтэй буюу 4.78-4.97 оноотойгоор үнэлэгдэв.

-Хөгжлийн 14 үзүүлэлтээс 13 үзүүлэлтийн биелэлтийг тооцоход 10 үзүүлэлт 100 хувийн үнэлгээтэй буюу 5 оноо, 4 үзүүлэлтийн 3 нь 92.0-96.8 хувийн үнэлгээтэй буюу 4.6-4.84 оноо авч харин “Улсын санд хүлээж авсан ойжуулсан талбайн хэмжээ (га/жил)” гэсэн үзүүлэлтийг шалгуур үзүүлэлтээс хасаж тооцов.

Эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтийн биелэлтийг өгөгдсөн шалгуур үзүүлэлтээр аймгийн хэмжээнд тооцоход 89.59 хувь буюу 4.48 оноотой гарч байна.

Эдийн засгийн ба нийгмийн үзүүлэлтүүдээс орон нутгийн төсвийн урсгал өрийн тоон үзүүлэлт болон өсөлт, бууралтын хувь өмнөх оныхоо түвшингээс 60.8-104.0 хувиар, нялхсын эндэгдлийн түвшин 16.8 хувь, тав хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 14.1 хувиар тус тус нэмэгдсэн учраас дээрхи 4 үзүүлэлтийг “0” хувийн гүйцэтгэлтэй буюу нойл оноотойгоор тооцож гаргав.

5.2.Хэрэглэгчдийн судалгааны үр дүнгийн талаар:

Монгол Улсын Засгийн газрын 2010 оны 11-р тогтоолын дагуу Засгийн газрын болон Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт иргэдийн ахуй амьдрал, амьжиргааны түвшинд хэрхэн нөлөөлж байгааг тодруулах зорилгоор иргэдийн дунд санал асуулгыг 2010 онд 4 удаагийн давтамжтай 13 суманд зохион явуулж 1400 иргэн судалгаанд хамрагдав. Энэ нь өнгөрсөн оноос судалгаанд оролцсон иргэдийн тоо 2 хувиар нэмэгдэж 5 хувьд хүрсэн байна.

Судалгааг явуулахдаа “Иргэний нийгмийн сүлжээ” төрийн бус байгууллага болон “Шинэ үеийн эхлэл” төрийн бус байгууллагуудыг бие даан оролцох нөхцөл боломжийг хангаж ажиллав. Энэ ажлын хүрээнд Засаг даргын нөөц сан болон Тамгын газрын төсвөөс 1.0 сая төгрөгийг гарган зарцуулсан байна.

Судалгаанд нийт 1400 хүн оролцсоны 260 нь төсөвт байгууллагаас, 290-нь хувийн хэвшил, бизнес эрхлэгчдээс, 270-нь малчин, 410-нь ажилгүй иргэд, 170-нь төрийн бус байгууллагаас хамрагдсан байна. Мөн үүнээс гадна агентлаг, албадын үйл ажиллагаатай холбогдуулан байгууллага тус бүрт 50 иргэн нийт 1200 иргэнийг хамруулсан судалгааг судалгаа шинжилгээний чиглэлээр үйл ажиллагаагаа явуулж байгаа орон нутгийн “Шинэ үеийн эхлэл” төрийн бус байгууллагаар гэрээний үндсэн дээр хийлгүүлсэн юм.

Засгийн газрын болон Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилттэй холбогдсон 8 асуулттай асуулгын дүнг нэтгэж үзэхэд **76.7** хувийн гүйцэтгэл, **3.83** оноотойгоор үнэлэгдсэн байна. Энэ байдал нь тус аймгийн хувьд тодорхой хөрөнгө оруулалт бүтээн байгуулалтын ажлуудыг хийж гүйцэтгэсэн, иргэдийн орлогыг нэмэгдүүлэх,

иргэдэд дэмжлэг туслалцаа үзүүлэх зэрэг бодлогын чанартай зорилтуудын хэрэгжилт нь иргэдийн амьдралд үр дүнгээ өгч байгааг илтгэн харуулж байна.

2010 онд хийгдсэн гол гол ажлын зурагтай товч танилцуулгыг хавсаргав.

ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР